



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 01 сарын 27 өдөр

Дугаар 2/14

Арвайхээр

Цалин шинэчлэн тогтоох тухай

Засгийн газрын 2014 оны 332 дугаар тогтоолын 1, 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээ", Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын "Төрийн нууцын хадгалалт, хамгаалалтыг сайжруулах зарим арга хэмжээний тухай" 2004 оны 007 дугаар захирамжийн 1-ийн "д", аймгийн Засаг даргын 2016 оны "Зэрэг дэвийн нэмэгдэл олгох тухай" а/92 дугаар захирамжийн 2, аймгийн Засаг даргын "Нэмэгдлийн хувийг өөрчлөх тухай" 2014 оны а/321 дүгээр захирамжийн 1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төрийн жинхэнэ албан хаагчийн 2016 оны үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээг харгалзан Засаг даргын Тамгын газрын дарга В.Шоовдорын сарын үндсэн цалинг ТЗ-7 зэрэглэлийн 5 дахь шатлалаар 733863 /Долоон зуун гучин гурван мянга найман зуун жаран гурав/ төгрөг, ахлах түшмэлийн тэргүүн зэрэг дэвийн нэмэгдэл 25 хувь 183465 /Нэг зуун наян гурван мянга дөрвөн зуун жаран тав/, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл 20 хувь 146772 /Нэг зуун дөчин зургаан мянга долоон зуун далан хоёр/, нууцын нэмэгдэл 10 хувь 73386 /Далан гурван мянга наян зургаа/, ХАСХОМ хариуцсаны нэмэгдэл 10 хувь 73386 /Далан гурван мянга наян зургаа/, бүгд 1210872 /Нэг сая хоёр зуун арван мянга найман зуун далан хоёр/ төгрөгөөр тооцож, шинэчлэн тогтоосугай.

2. Шинэчлэн тогтоосон цалинг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж олгохыг Нягтлан бодогч /М.Отгон/-д зөвшөөрсүгэй.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан "Цалин шинэчлэн тогтоох тухай" 2016 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн а/10 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ДАРГА

О.ПҮРЭВДОРЖ



14 0027